



УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Төслийн хэрэгжилтийн тайлан



2022 оны 1 дүгээр сар



ШИНЭ ДЭД ТӨВ

АГУУЛГА

1. Төсөл, арга хэмжээний нэр.....	2
2. Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага	2
3. Төсөл, арга хэмжээний зорилго	2
4. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага.....	2
5. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр:.....	2
6. Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт.....	3
7. Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт	3
8. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ	4
9. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд	5
ХӨТӨЛБӨРИЙН I ҮЕ ШАТ	6
Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа	7
Худалдан авах ажиллагааны явц	8
Барилга угсралтын ажлын явц	9
ХӨТӨЛБӨРИЙН II ҮЕ ШАТ	13
Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц	14
Худалдан авах ажиллагааны явц	16
Барилга угсралтын ажлын явц	17
ХӨТӨЛБӨРИЙН III ҮЕ ШАТ	20
Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явц	20
Худалдан авалтын үйл ажиллагаа	21
Барилга угсралтын ажлын явц	22
10. Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд.....	23
11. Тулгамдаж буй асуудлууд	23
12. Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	26
13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл	26

ХӨТӨЛБӨР

1. **Төсөл, арга хэмжээний нэр:** Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр
2. **Хөгжлийн түнш/ санхүүжүүлэгч байгууллага:** Азийн хөгжлийн банк (АХБ), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)
3. **Төсөл, арга хэмжээний зорилго:** Гэр хорооллын бүсэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулснаар Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бий болгоход оршино.


“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичигт заасан эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгох зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

4. **Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)
5. **Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр:** АХБ-ны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл болон НЗДТГ-ын санхүүжилт



Эх үүсвэр	Хөтөлбөр	I үе шат	II үе шат	III үе шат
АХБ-ны санхүүжилт	163.7	53.7	66.35	43.65
(COL)	70.34	22.5	29.24	18.6
(OCR)	89.66	27.5	37.11	25.05
МОН-0380	3.7	3.7	-	-
НЗДТГ-ын төсөв	120.2	33.15	35.15	51.9
ЕХОБ-ны санхүүжилт	60.3	22.01	19.64	18.65
Нийт	344.2	108.86	121.14	114.2

Төсөл хэрэгжүүлэх дэд төвүүдийн байршил



6. Тайлан хугацаанд гарсан ашиглалт, санхүүжилт:

2021 оны Улсын төсөв

(төгрөгөөр)

Данс	Дансны нэр	Төсөв	Гүйцэтгэл	%
100900011825	MON-3099 (COL)	4,412,010,000.00	3,850,750,662.04	87.28%
100900011826	MON-3098 (OCR)	28,936,190,000.0	1,589,803,583.18	5.49%
100900011827	EIB FI'83.097	8,000,230,000.0	2,776,028,263.03	34.70%
100900011898	MON-3525 (OCR)	17,761,580,000.00	2,114,389,766.50	11.90%
100900011899	MON-3526 (COL)	16,555,750,000.00	2,941,404,128.08	17.77%
100900011900	EIB FI'83.873	15,308,500,000.00	4,322,448,102.08	28.24%
	Нийт	90,974,260,000.00	17,594,824,504.91	19.34%


7. Төсөл, арга хэмжээний нийт ашиглалт:

№	Үе шат	Эх үүсвэр	Ашиглалт (сая ам.доллар)		
			Батлагдсан	Зарцуулсан ашиглалт	%
1	I үе шат (Сэлбэ, Баянхошуу дэд төв)	АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл	75.71	66.56	87.91%
		Нийслэлийн төсөв	33.15	33.03	99.64%
		Нийт	108.86	99.59	91.48%
2	II үе шат (Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төв)	АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл	85.99	28.96	33.68%
		Нийслэлийн төсөв	35.15	3.87	11.01%
		Нийт	121.14	32.83	27.10%

3	III үе шат (Шархад, Толгойт дэд төв)	АХБ, ЕХОБ-ны хөнгөлөлттэй зээл	62.3	-	0.00%
		Нийслэлийн төсөв	51.9	-	0.00%
		<i>Нийт</i>	<i>114.2</i>	-	<i>0.00%</i>
Хөтөлбөр			344.2	132.42	38.47%

8. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь хэмжээ:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий явцыг дараах байдлаар үзүүлэв



Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нь тайлант хугацаанд 44.07% байгаа бөгөөд энэ нь 2021.12.25-ны өдөртэй харьцуулахад 0%-ын өсөлттэй байна. Дараах хүснэгтээс үе шат бүрээр хэрэгжилтийг харна уу

Үе шат	Санхүүжилт	Үйл ажиллагаа	Бодит явц
Үе шат I	108,860,000.00	ТУН байгуулах	100.00%
		Үйл ажиллагаа	97.92%
Үе шат II	121,140,000.00	Үйл ажиллагаа	33.27%
Үе шат III	114,200,000.00	Үйл ажиллагаа	2.46%
		Төслийн хаалт	0.00%
Нийт	344,200,000.00		44.07%

Хөтөлбөрийн нийт төлөвлөсөн хэрэгжүүлэх хугацааны 81.25% нь өнгөрөөд байгааг дараах зайлшгүй нөхцөл байдлуудын улмаас төслийн хэрэгжилтийн явц удаашраад байна. Үүнд:

- Хөтөлбөрийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төсөв хөрөнгө дутмаг
- Засгийн газраас хэрэгжүүлж байгаа дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнүүдийн хүрээнд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдтэй уулзалт зохион байгуулах, зөвшилцөх ажлыг сүүлийн 2 жилийн хугацаанд зохион байгуулах боломжгүй болсон.
- Мөн энэхүү цар тахлын тархалт улам ихсэж байгаагаар холбогдуулан олон нийтийн хөл хорио тогтоон барилгын ажлыг зогсоосон мөн бараа материал татан авалтад хугацаа их зарцуулж байна. (2020 оны 11 сард Ковид-19-ын анхны тохиолдолд бүртгэгдсэнээс хойш нийт 7 удаагийн нийт 78 хөл хорио тогтоосон бөгөөд 2020 оны 1 сараас эхлэх хилийг хааж бараа материал нэвтрүүлэхэд хүндрэл ихтэй удаашралтай болсон.)
- Барилга угсралтын ажлын өвлийн нөхцөл, технологитой холбоотойгоор өвлийн турш ихэнх ажил сул зогсолт хийсэн.
- Зээлийн хэлэлцээрт заасан Нийслэлийн хариуцах барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилт олгогдохгүй хугацаа хоцорч байна.
- Нийслэлийн төсөв тасарснаас 2020 оны 9 сараас эхлэн Нийслэлийн хариуцах барилга угсралтын ажлын төлбөрүүд төлөгдөх боломжгүй болсон.

Мөн АХБ-ны ажлын хэсэг төслийн хэрэгжилтэд хяналт тавин 2021.06.04-нөөс 29-ны хооронд ажилласан бөгөөд төслийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг холбогдох талуудтай хэлэлцэн хугацаа одоогийн нөхцөл байдлаас шалтгаалан хоцорч байгаа хугацааг хэрхэн нөхөх хөрөнгө оруулалтуудыг хэрхэн дахин хуваарилах талаар саналаа солилцсон бөгөөд Хяналтын ажлын хэсгийн хүрээнд санамж бичиг зурахаар хамтран ажиллаж байна.

9. Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд:

ХӨТӨЛБӨРИЙН I ҮЕ ШАТ

Тайлангийн хугацаанд төслийн нийт хэрэгжилтийн явц өссөн дүнгээр 97.92%-д хүрсэн ба энэ нь 2020 оны эцэстэй харьцуулахад 8.85%-иар өссөн байна.

Энэ үе шатны хүрээнд дараах инженерийн болон нийгмийн барилга байгууламжуудыг дэд төвүүдэд барихаар төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилтийн тоймыг дараах хүснэгтээс харна уу

Барилга байгууламж	Баянхошуу дэд төв	Сэлбэ дэд төв
Автозам	6.5 км төлөвлөснөөс 6.1 км хийгдсэн	7.6 км төлөвлөснөөс 7 км хийгдсэн
Цахилгааны шугам сүлжээ	6.3 км төлөвлөснөөс 6.3 км хийгдсэн	2.4 км төлөвлөснөөс 2.4 км хийгдсэн
Дулаан хангамжийн шугам сүлжээ	16.8 км төлөвлөснөөс 16.2 км хийгдсэн	8.7 км төлөвлөснөөс 8.5 км хийгдсэн
Ус хангамжийн шугам сүлжээ	10.9 км төлөвлөснөөс 10.7 км хийгдсэн	7 км төлөвлөснөөс 7 км хийгдсэн
Ариутгах татуургын шугам сүлжээ	16.6 км төлөвлөснөөс 16.2 км хийгдсэн	11.5 км төлөвлөснөөс 11.2 км хийгдсэн
Үерийн хамгаалалтын далан суваг	4.7 км төлөвлөснөөс 4.7 км хийгдсэн	2.2 км төлөвлөснөөс 2.2 км хийгдсэн
Харилцаа холбооны шугам сүлжээ	2.9 км төлөвлөснөөс 2.9 км хийгдсэн	2.8 км төлөвлөснөөс 2.8 км хийгдсэн
Талбайн тохижилт	4.65 га талбайн ажил – 100%	3.01 га талбайн ажил – 100%
Усан сан	1000м ³ усан сан, 2ш насос станц - 100%	1000м ³ усан сан, 1ш насос станц - 100%
Төмөр бетон гүүр	-	3ш /60м, 30м, 24м/ – 100%
Дулааны станц	-	26 МВт – 90.75%
Мэдээлэл холбооны үйлчилгээний нэгдсэн төв	1ш – 100%	1ш – 100%
Бизнес инкубатор, сургалтын төв	1ш – 100%	1ш – 100%
Цэцэрлэг	240 хүүхдийн ортой, 1ш – 100%	240 хүүхдийн ортой, 1ш – 100%
Орлогод нийцэн орон сууц	20 айлын орон сууц – 95%	-

Энэхүү үе шатны хүрээнд гүйцэтгэгдэж байгаа үйл ажиллагаануудын хэрэгжилтийн явцыг дараах хүснэгтэд үзүүлэв.

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн хувь
1	Газар чөлөөлөлт, Нүүлгэн шилжүүлэлт	100%
1.1	ГЧНШ-ын төлөвлөлт	100%
1.2	ГЧНШ-ын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	100%
2	Худалдан авалтын үйл ажиллагаа	100%
2.1	Ажил	100%
2.2	Бараа	100%
2.3	Зөвлөх үйлчилгээ	100%
3	Барилгын ажлын явц	96.60%
3.1	Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	94.54%
3.2	Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын менежментийг бэхжүүлэх	100%

3.3	Нийгэм, эдийн засгийн барилга байгууламж	99.66%
4	Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх	99.19%
	Нийт	97.92%

ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ үе шатны хүрээнд төлөвлөгдсөн байсан газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажил бүрэн хэрэгжсэн бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна.

1. Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ болон нийгмийн барилга байгууламжийн барилгын ажлын нөлөөлөлд өртсөн нийт 1229 нэгж талбар байгаагаас, иргэдтэй зөвшилцөн 1223 айл өрх иргэд нөхөн төлбөрөө бүрэн хүлээж авсан байна.

Байршил /дэд төв/	Ажлын нэр	Нөлөөлөлд өртсөн нэгж талбарын тоо				Нөхөн төлбөр төлөгдсөн өрхийн тоо	Нийт нөхөн олговор
		Нийт	бүтэн	Хагас	Газрын эрхгүй өрхүүд		
Баян- хошуу	Авто зам, инженерийн шугам сүлжээ	447	130	211	106	447	12,903,381,467
	Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ-ын дэд өртөө	27	27	0	0	27	2,270,437,005
	Усан сан	11	9	2	0	11	293,491,344
	Бохир усны коллекторын ажил	104	15	89	0	104	1,146,487,178
	Дулааны төвлөрсөн дулаанд холбох шугам	59	16	35	8	59	1,535,126,627
Бүгд		648	197	337	114	672	18,148,923,621
Сэлбэ	Авто зам, инженерийн шугам сүлжээ	492	190	154	148	486	18,104,299,308
	Дулааны станц	28	27	0	1	28	2,160,010,339
	Цэцэрлэг, МСҮТ, Цахилгааны 35/10кВ-ын дэд өртөө	26	26	0	0	26	2,285,557,375
	Бохир усны коллекторын ажил	19	0	19	0	19	96,051,731
Бүгд		565	243	173	149	559	22,645,918,753
КТМС-с Талх чихэр хүртлэх цэвэр болон бохир усны 11 км шугам		16	5	10	1	16	308,695,254
Нийт		1229	445	520	264	1223	41,103,537,628

2. Нөлөөлөлд өртөн газраа хагас чөлөөлсөн нийт 317 нэгж талбарын кадастрын зургийн өөрчлөлтийг Нийслэлийн газрын мэдээллийн санд оруулж нийт 278 нэгж талбарын кадастрын зураглал, газрын гэрчилгээг иргэдэд олгоод байна.

Дэд төв	Эдэлбэрийн хэлбэр	Шинэчилсэн гэрчилгээ авах иргэдийн тоо	Шинэчилсэн гэрчилгээний тоо	Шинэчилсэн гэрчилгээ хүлээн авсан иргэдийн тоо	УБХ дээр материал хүлээгдэж байгаа	ДГЗБА хүлээгдсэн	Иргэнээс хамааралтай хүлээгдсэн
Баянхошуу	Өмчлөх	184	170	170	12		2
	Эзэмших	19	12	12		7	
	Нийт	203	182	182	12	7	2
Сэлбэ	Өмчлөх	101	94	91		2	5
	Эзэмших	13	2	2		11	
	Нийт	114	96	93	0	13	5

3. Нөлөөлөлд өртсөн газар эзэмших, өмчлөх эрхгүй нийт 266 өрх байсан бөгөөд тэдэнд суурь дэд бүтцээр хангагдсан нийтийн үйлчилгээтэй газар олгох эсвэл зорилтот бүлгийн орон сууц санал болгох зэрэг боломжит хувилбаруудыг санал болгон баталгаажуулж, тухайн иргэдтэй зөвшилцөн сонгосон хувилбаруудыг Нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 2020.03.12-ны өдөр хэлэлцүүлж, хурлын шийдвэрийн дагуу боломжит газруудын эзэмшлийг өөрчлөн Нийслэлийн Засаг даргын А/421, А/422 тоот захирамжуудыг батлуулсан.
4. НЗД-ийн 2021 оны А181 дүгээр захирамжаар Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Морингийн даваанд нийт 189 иргэнд газар эзэмшүүлэх захирамж гарсан ба үүнээс 184 иргэний гэрчилгээ олгогдоод байна. Үлдсэн иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулах тухай албан тоотыг НГЗБА-нд НЗДТГ-аар дамжуулан 2021 оны 07 дугаар сарын 6-нд хүргүүлсэн байна

Дэд төв	Нийт	37 байршил газар сонгосон	Морин даваанд газар сонгосон	Газар сонгохгүй гэсэн	Түрээслээд өмчлөх байр сонгосон	Газар сонгоогүй
Баянхошуу	98	25	47	2	13	11
Сэлбэ	155	55	67	4	21	8
Нийт	253	80	114	6	34	19

Хэдийгээр газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагаа дууссан ч тайлант хугацаанд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна.

- Шинэчилсэн кадастрын зураг, гэрчилгээ гаргах чиглэлээр Нийслэлийн Улсын Бүртгэлийн газраас шинэчлэгдсэн гэрчилгээний төлбөрийг гүйцэтгэлээр гаргуулах нь удаан үе шаттайгаас гадна гэрчилгээг шинэчлэх ажил удаашралтай явагдаж байна. Иймд Нийслэлийн төрийн сангийн мэргэжилтэн н.Сүхболдтой уулзаж, шийдвэрлүүлэхээр болсон.
- Үе шат 1,2 хүрээнд хийгдсэн ГЧНШ-ийн холбогдох баримт бичиг болох 2500 хуудас гаруй материалыг архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

Хөтөлбөрийн 1 үе шатны хүрээнд худалдан авалтын төлөвлөгөөнд АХБ-ны хүсэлтийн дагуу 2021.07.06-нд өөрчлөлт оруулан шинэчлэгдэн батлагдсан бөгөөд энэхүү худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 32 барилгын ажил, 16 зөвлөх үйлчилгээ, 11 бараа худалдан авалтын нийт 59 ажлын худалдан авалтын бүрэн зохион байгуулж дууссан байна. Хил гааль дөнгөж нээгдэж байгаатйа холбогдуулан зарим худалдан авсан барааг хэрэглэгч байгууллагад бүрэн хүлээлгэж өгө ажил удаашралтай байна.

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦ

Тайлангийн хугацаанд төслийн барилга угсралтын бодит явц 96.60%-тай хэрэгжиж байна. Эхний үе шатны хэрэгжилтийн явцад нийт 26 барилгын ажлыг улсын комисст хүлээлгэн өгөөд байгаа бөгөөд 6 барилгын ажлыг ашиглагч байгууллагын өмчид бүртгүүлэн хүлээлгэн өгөөд байна. Бусад улсын комисст хүлээлгэн өгсөн барилгуудыг Нийслэлийн өмчийн ашиглалтын газарт хүлээлгэн өгөх үйл ажиллагаа үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд дараах төлөвтэй байна

№	Барилгын ажлын нэр	Улсын комисс ажилласан огноо	Хөрөнгөд бүртгэсэн огноо/ захирамж дугаар
АХБ-ны санхүүжилт			
1	WWOI: Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах ажил	11/28/2018 № 2018/650	3/17/2020-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
2	BSF05 Багц1: Баянхошуу дэд төвд баригдсан 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга	12/11/2018 №2018/737 12/7/2018 №2018/709	7/3/2020 НЗД-ын А/936 тоот захирамж
3	BSF05 Багц2: Баянхошуу дэд төвд баригдсан бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга	6/21/2019 №2019/200	4/23/2020 НЗД-ын А/565 тоот захирамж
4	BHF06: Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	09/18/2019 №2018/358	10/8/2020 ТӨБЗГ-ын 477 дугаартай захирамжаар хөрөнгө бүртгэсэн
5	SSF05 Багц1: Чингэлтэй дүүргийн 18-р хороо, Сэлбэ дэд төвд баригдсан 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга	8/27/2020 №БА-016/2020	3/9/2021 НЗД-ын А/135 тоот захирамж
6	SSF05 Багц2: Чингэлтэй дүүргийн 18-р хороо, Сэлбэ дэд төвд баригдсан бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга	9/9/2020 № БА-027/2020	9/6/2021 НЗД-н А/685 тоот захирамжаар хөрөнгөөр бүртгэсэн
7	SBR08: 24м, 30м, 60м урттай, төмөр бетон 3ш гүүр	12/7/2020	Гүйцэтгэгч байгууллагаас эцсийн гүйцэтгэлийг авсны дараа НӨАУГ-т хүлээлгэн өгөх материалыг бэлтгэнэ

8	BSLS09 Багц1: Баянхошуу дэд төвийн 4.65 га талбайн тохижилтын ажил	8/27/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
9	SRDH14: Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 2	9/7/2021 10/18/2021 10/19/2021 10/21/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
10	BSLS09 Багц 2: Сэлбэ дэд төвд үерийн далангийн дагуу хийгдэх гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил	10/18/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
11	SRDH14: Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 2	09/07/2021 10/19/2021 10/21/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, ТӨБЗГ болон НӨАУГ-т хүргүүлнэ.
12	БЕС13: Баянхошуу дэд төвийн цахилгаан болон холбооны шугам сүлжээний барилга угсралтын ажил	09/27/2021	Холбооны болон цахилгааны шугам сүлжээний ажилд улсын комисс ажилласан бөгөөд бусад ажлуудад улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.
13	BRDH14: Баянхошуу дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 2	09/27/2021 01/04/2022	Авто зам, УДДТ, холбооны болон цахилгааны шугам сүлжээний ажилд улсын комисс ажилласан бөгөөд бусад ажлуудад улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.
14	BRDH11: Баянхошуу дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 1	11/16/2021	Ус хангамж, ариутгах татуурга дулааны шугам сүлжээний ажилд улсын комисс ажилласан бөгөөд бусад ажлуудад улсын комисс ажиллахаар бэлтгэж байна.
15	SRDH11: Сэлбэ дэд төвд баригдах авто зам, дулааны болон дэд бүтцийн шугам сүлжээний барилга угсралтын ажил - Үе шат 1	11/16/2021	
ЕХОБ-ны санхүүжилт			

16	BCM1: 4116 Метр DM450&500-ийн зөөлөн ширмэн (3ш) хоолойтой Баянхошууны 1-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил	12/21/2016 №2016/625	3/26/2021-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
17	BCM2: Баянхошууны ариутгах татуургын 2-р хэсгийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн (3ш) хоолой бүхий ариутгах татуургын шугамын барилгын ажил	10/24/2017 №2017/283	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
18	SCM: Сэлбийн 2183 М DN400-ийн зөөлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын ажил	12/28/2017 №2017/605	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
19	BSDF07 Багц1: Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил	11/19/2018 №2018/617	8/20/2020-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
20	BSDF07 Багц2: Сэлбэ дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажил	12/5/2018 № 2018/690 9/10/2020 № БА-030/2020	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол хүлээгдэж байна
21	WSNR17C: Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил	7/16/2019 № 246	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
22	WWTPR01: Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил	7/22/2019 № 2019/255	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
23	BSWR10 Багц2: Сэлбэ дэд төвд усан сан, насос станцын барилга угсралт болон ус хангамжийн шугам хоолой нийлүүлж, суурилуулах ажил	11/29/2019 №2019/783 10/21/2019 № 2019/483	2021.08.17-ны өдөр НИТХ-аар орсон
24	BSWR10 Багц1: Баянхошуу дэд төвийн 1000м3 усан сан, насос станц, ус дамжуулах шугам	9/11/2020 № ШС-34/2020	НХОГ-аас 2021.08.04 -с НӨАУГ-т хүсэлт хүргүүлсэн
25	WSNR16A: Салбар шугамын холболт	08/13/2021	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
26	BSDF07B: Баянхошуу Үерийн хамгааллын суваг, шинэ	11/18/2021	

Барилгын ажлын улирал дууссантай холбогдуулан нийт 9 барилгын ажлыг түр зогссон байгаа бөгөөд барилгын ажил бүрэн дууссан 5 ажлыг улсын комисст хүлээлгэн өгөх ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэгдэж байна.

№	Багцын дугаар	Ажлын нэр	Бодит явц	
			2021.06.25-ны байдлаар	2022.01.25-ны байдлаар
Бүрэлдэхүүн 1				

	АХБ-ны зээл			
1	SHF06	Сэлбэ Дулааны станц, 26МВт, 1ш	86.03%	90.75%
2	BRDH11	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 1		93.5%
3	BRDH14	Баянхошуу Автозам, дулаан, ус, бохирын шугам сүлжээ - Үе шат 2	87.32%	95.00%
4	BEC13	Баянхошуу Цахилгаан, холбооны шугам сүлжээ	88.98%	97.55%
5	SEC13	Сэлбэ Цахилгаан, холбооны шугам сүлжээ	97.50%	97.50%
	ЕХОБ-ны санхүүжилт			
6	WSNR17A	Улаанбаатар хотын зүүн хойд бүсийн усан сангаас Тасганы усан сан хүртэлх ,	42.45%	60.01%
7	WSNR17B	Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан, баруун дүүргийн насос станц хүртэлх 7054м	60.24%	83.54%
8	BSDF07B	Баянхошуу Үерийн хамгааллын суваг, шинэ	81.80%	95.00%
	Бүрэлдэхүүн 3			
9	PP01-SW	Баянхошуу дэд төвд Орлогод нийцсэн орон сууцны туршилт, 20 айлын орон сууц, 1ш	76.00%	95.10%
10	TFBA	Чөлөөлсөн талбайг хашаалах НОСК, 1500м	22.75%	100%

Дээрх барилгын ажлуудын хэрэгжилтийн явц Нийслэлийн төсөв тасартсантай холбоотойгоор удаашраад байгаа бөгөөд барилгын ажлын улирал эхлэхэд үргэлжлүүлэн гүйцэтгэгдэхээр байна.

ХӨТӨЛБӨРИЙН II ҮЕ ШАТ

Тайлангийн хугацаанд төслийн нийт хэрэгжилтийн явц өссөн дүнгээр 33.27%-д хүрсэн байна.

Энэ үе шатны хүрээнд дараах барилга байгууламжуудыг дэд төвүүдэд барихаар төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилтийн тоймыг дараах хүснэгтээс харна уу

Барилга байгууламж	Баянхошуу дэд төв	Дамбадаржаа дэд төв	Дэнжийн мянга дэд төв
Автозам	-	3.3 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан.	1.1 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 90%
Цахилгааны шугам сүлжээ	-	12 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	20 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.
Дулаан хангамжийн шугам сүлжээ	4.9 км км хийгдсэн	5.6 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	8.2 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 80%
Ус хангамжийн шугам сүлжээ	-	3.5 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	8.2 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 90%
Ариутгах татуургын шугам сүлжээ	-	4.5 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөл магадлалаар батлагдсан бөгөөд ТББ-ын бэлтгэж эхэлж байна.	5.7 км төлөвлөсөн Зураг төслийн боловсруулалт явц – 90%
Үерийн хамгаалалтын далан суваг	-	1.5 км төлөвлөсөн Ажлын нарийвчилсан зураг төсөлд 2020 онд магадлал хийгдсэн. -100%	3.5 км төлөвлөсөн Нарийвчилсан зураг төслийг магадлалаар батлуулсан бөгөөд ХАА үйл ажиллагаа эхэлж байна
Цэцэрлэгт хүрээлэн	Барилгын ажлын явц – 54%	-	-
Дулааны станц /Эх үүсвэр/	-	63МВт дулааны станцын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил 83%	-
Мэдээлэл холбооны үйлчилгээний төв	-	Зураг төслийн боловсруулалтын явц - 50%	Зураг төслийн боловсруулалтын явц - 50%
Олон нийтийн хөгжлийн төв	Барилгын ажлын явц – 13%	Зураг төслийн боловсруулалтын явц - 90%	-

Цэцэрлэг	Барилгын ажлын явц – 10%	150 хүүхдийн цэцэрлэг Нарийвчилсан зураг төслийг магадлалаар батлуулсан бөгөөд ХАА үйл ажиллагаа эхэлж байна.	240 хүүхдийн цэцэрлэг Зураг төслийн боловсруулалтын явц – 21%
Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр	ХАА-ын үйл ажиллагааг дахин эхлүүлсэн. ХАА-ны явц -67.5%-тай байна	-	-
Нэгдүгээр зэрэглэлийн аврах, гал түймэр унтраах 29 дүгээр ангийн барилга	ХАА-ын үйл ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд явц нь 19% байна.	-	-
Спорт цогцолбор	Гэрээг байгуулсан бөгөөд барилгын ажлын улирал дууссан тул барилгын ажлыг эхлүүлээгүй байна	Газар чөлөөлөлт хийгдээгүйн улмаас зураг төслийн ажил зогссон, хүлээлтийн байдалтай байна. - 21%	-

Энэхүү үе шатны хүрээнд гүйцэтгэгдэж байгаа үйл ажиллагаануудын хэрэгжилтийн явцыг дараах хүснэгтэд үзүүлэв.

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн хувь
1	Газар чөлөөлөлт, Нүүлгэн шилжүүлэлт	62.56%
1.1	ГЧНШ-ын төлөвлөлт	67.14%
1.2	ГЧНШ-ын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	57.99%
2	Худалдан авалтын үйл ажиллагаа	44.98%
2.1	Ажил	43.43%
2.2	Бараа	52.13%
2.3	Зөвлөх үйлчилгээ	95.10%
3	Барилгын ажлын явц	20.94%
3.1	Авто зам болон хотын үндсэн үйлчилгээг өргөжүүлэх	25.03%
3.2	Нийгэм, эдийн засгийн барилга байгууламж	10.07%
4	Төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх	37.72%
	Нийт	33.27%

ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ЯВЦ

Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт 6 төлөвлөгөө, 7 зохистой байдлын тайлан боловсруулж АХБ-аар баталгаажуулахаас 7 зохистой байдлын тайлан боловсруулаад байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон зохистой байдлын тайланг боловсруулахад тухайн сонгосон байршил болон амьдарч буй иргэдтэй зөвлөлдөх

уулзалтууд хийх болон нөлөөлөлд өртөх магадлалтай иргэдээс нийгэм эдийн засгийн судалгаа авах шаардлагатай байдаг. Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн КОВИД-19 цар тахал гарсны улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон тул эдгээр ажлуудыг хийх боломжгүй байдал үүсэж, тодорхойгүй хугацаагаар хойшилж байгаа нь төслийн нийт ажлыг хугацаа хоцроох эрсдэлтэй байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нийт ажлын явц тайлангийн хугацаанд 67.16%-д хүрсэн байна.

Төслийн зураг төслүүд дуусаж байгаатай холбогдуулан дараах хүснэгтэд заасан нэгж талбарыг чөлөөлөхөөр төлөвлөөд байна.

Дэд төв	Барилга	Нөлөөлөлд өртсөн нэгж талбар			
		Нийт	Бүтэн	Хагас	Газрын эрхгүй
Баянхошуу	240 хүүхдийн цэцэрлэг	1	1		
	Үерийн далан	34	13	18	3
	Дулааны шугам	26	5	16	5
	Автозам	46	31		15
	Цэцэрлэгт хүрээлэн	1	1		
Нийт		108	51	34	23
Дамбадаржаа	150 хүүхдийн цэцэрлэг	15	11		4
	Мэдээлэл холбооны техникийн барилга	2	1		1
	Дулааны станц	50	41		9
	Автозам, инженерийн шугам сүлжээ	203	127	3	73
	Автозам, инженерийн шугам сүлжээ / 2 хэсэг	65	9	46	10
Сэлбэ	OSPF	6		5	1
Нийт		341	189	54	98
Нийт		449	240	88	121

Тайлант хугацаанд дараах хэсгүүдийн газруудыг чөлөөлөн нөхөн олговрыг олгоод байна

Дэд төв	Ажлын нэр	Бүтэн	Хагас	Газрын эрхгүй өрх	НО-ын гэрээ хийсэн	Нийт нөхөн олговрын дүн
2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/863 тоот						
Дамбадаржаа	150 Хүүхдийн цэцэрлэг	11		4	15	996,442,256
	Холбоо мэдээлэл, технологийн техникийн байр	1		1	2	97,464,486
	Дүн	12		5	17	1,093,906,742
	2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/526 тоот					
	Дулааны станц	41		9	50	3,117,632,713
	Автозам, инженерийн барилга байгууламж	122	2	65	189	11,591,804,596


Баянхошуу	Цэцэрлэгт хүрээлэн	1			1	70,608,727
Сэлбэ	OSPF	5		1	6	131,156,637
	Дүн	169	2	75	246	14,911,202,673
Нийт дүн		181	2	80	263	16,005,109,415

Тайлант хугацаанд дараах ажлуудыг гүйцэтгээд байна.

- Дамбадаржаа дэд төвийн авто замын нөлөөлөлд өртөж нөхөн олговороо авсан 42 иргэнд гэрээний 1% хүлээлгэн өгч ажилласан
- Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын нөлөөлөлд өртөөгүй айл өрхүүд нь хашаагаа зөвшөөрөлгүй сунгах, чөлөөлөгдсөн талбайд модон жорлон барих гэх мэт зөрчлүүд гаргаж байгаа тул НГЗБА-тай хамтран чөлөөлөгдсөн талбайд улаан шугам татуулж, кадастрын зураг хийлгэсэн ба нөлөөлөлд өртөөгүй айл өрхүүдэд мэдэгдэх хуудсаар дамжуулан дээрхи зөрчлүүдээс сэргийлэх ажлуудыг зохион байгуулж байна.
- Дамбадаржаа дэд төвийн авто замын нөлөөлөлд өртөж газраа чөлөөлсөн 107 өрхийн үл хөдлөх болон газрын гэрчилгээний хуулбарыг хүчингүй болгуулахаар СБД-ийн УБХ-т хүлээлгэн өгсөн ба 25 өрх нь зээлийн мэдээллээ устгуулаагүй учраас иргэн бүртээ холбогдож мэдээлэл хүргэсэн.
- Дамбадаржаа дэд төвийн авто замын нөлөөлөлд өртөгч 1 иргэнээс ирсэн гомдлыг судалж, албан бичгээр хариу өгч ажилласан.
- Сэлбэ дэд төвд баригдсан нийгмийн барилга байгууламжийг дулаанаар хангах, Эко-Цайз /Шархад дэд төв/ хотхоныг инженерийн дэд бүтцээр хангах ажлын ГЧНШ-ийн баримт бичиг болох Нийцтэй байдлын тайланг батлуулж АХБ-ны вэб сайтад байршуулсан.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ

2021.09.16-ны өдөр шинэчлэгдэн батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 30 барилгын ажил, 6 бараа, 7 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 13 барилгын ажил, 3 бараа, 5 зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулаад байна.



Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц 44.98%-тай байна.

- **SFS (дахин зар): Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байрны барилга угсралтын ажил**
Тендерийг 2021 оны 11-р сарын 30-нд зарласан. Материал хүлээн авах эцсийн хугацаа 2022 оны 1-р сарын 3-нд товлөгдсөн. Товлосон хугацаанд тендерийн материал ирээгүй тул гэрээ шууд байгуулах аргаар худалдан авалтыг хийх зөвшөөрлийг АХБ-нд илгээсэн бөгөөд тайлбар үндэслэл боловсруулж байна.
- **ASKG-DA: Дамбадаржаа дэд төвд баригдах 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралт**
Тендерийг 2022 оны 1-р сарын 24-нд зарласан боловч НЗДТГ-ын мэдэгдлийн дагуу цуцалсан.
- **FSBKH: Сонгинохайрхан дүүргийн 40-р хороо, Гал унтраах аврах 29 дүгээр анийн барилга угсралтын ажил**
Тендерийг 2021 оны 12-р сарын 24-нд зарласан. Материал хүлээн авах эцсийн хугацаа 2022 оны 1-р сарын 28-нд товлөгдсөн. Товлосон хугацаанд тендерийн материал ирээгүй.
- **DAFPE: Дамбадаржаа дэд төвд баригдах үерийн хамгаалалтын далан, сувгийн ажил**
Тендерийг 2021 оны 12-р сарын 2-нд зарласан. Материал хүлээн авах эцсийн хугацаа 2022 оны 1-р сарын 4-нд товлөгдсөн. Товлосон хугацаанд нэг санал хүлээн авсан. Үнэлгээний хороо үнэлгээг эхлүүлж тайлан боловсруулж байна.

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦ

Тайлангийн хугацаанд хөтөлбөрийн I үе шатанд боловсруулагдсан барилга угсралтын ажлуудын нарийвчилсан зураг төслийн дагуу 5 барилгын ажил гүйцэтгэгдэж дууссан байна.

Энэхүү үе шатанд гүйцэтгэсэн барилгын ажлуудыг НӨАГ-т хүлээлгэн өгөх үйл ажиллагаа дараах төлөвтэй байна.

№	Барилгын ажлын нэр	Улсын комисс ажилласан огноо	Хөрөнгөд бүртгэсэн огноо/ захирамж дугаар
АХБ-ны санхүүжилт			
1	GWD11: Хөрсний ус зайлуулах шугам - Үе шат 1	10/12/2020 № ИС-63/2020	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол хүлээгдэж байна
2	GWD14: Хөрсний ус зайлуулах шугам - Үе шат 2	10/30/2020 № ИС-89/2020	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол хүлээгдэж байна
ЕХОБ-ны санхүүжилт			
3	BHF06B: Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны 11и магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	02/08/2021 № ИС-028/2021	8/20/2020-д НӨАУГ-т албан хүсэлт хүргүүлсэн
4	WSC16B: Салбар холболтууд	08/05/2021 10/07/2021	Хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протокол үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.
5	HSSC-B: Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний угсралтын ажил	10/07/2021	Улсын комиссын акт баталгаажихаар хөрөнгийн задаргаа, гэрээ дүгнэсэн протоколыг үйлдэж, НӨАУГ-т хүргүүлнэ.

Инженерийн зураг төсөл боловсруулалт

- Хөтөлбөрийн үе шат II-ийн хүрээнд баригдах барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төслийг боловсруулалтын явц дараах байдалтай байна. Үүнд:

№	Барилгын ажлын нэр	Зураг төсөл боловсруулалтын явц
1	Дамбадаржаа дэд төвийн үерийн хамгаалалтын суваг	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
2	Дамбадаржаа дэд төвийн авто зам болон инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
3	Дамбадаржаа дэд төвийн цахилгаан холбооны ажил	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
4	Дамбадаржаа дэд төвийн дулааны станц	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
5	Дэнжийн мянга дэд төвийн үерийн хамгаалалтын суваг	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
6	Дэнжийн мянга дэд төвийн цахилгаан холбооны ажил	80%

7	Дэнжийн мянга дэд төвийн авто зам болон инженерийн хангамжийн шугам сүлжээний ажил	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
8	Дамбадаржаа дэд төвийн дулааны станц	10%
9	650 хүний суудалтай Спорт Цогцолбор /Баянхошуу дэд төв/	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
10	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
11	Спорт Цогцолбор /Дамбадаржаа дэд төв/	Газар чөлөөлөлт хийгдээгүйн улмаас зураг төслийн ажил зогссон, хүлээлтийн байдалтай байна. - 21%
12	Олон Нийтийн Хөгжлийн төв /Дамбадаржаа дэд төв/	Газар шийдэгдээгүй учир зураг төсөл боловсруулалтыг хийж эхлээгүй байна.
13	150 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дамбадаржаа дэд төв/	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан
14	240 хүүхдийн цэцэрлэгийн барилга /Дэнжийн мянга дэд төв/	Газар шийдэгдээгүй учир зураг төсөл боловсруулалтын ажил түр зогссон байна.
15	Гал унтраах ангийн барилга	Зураг төсөл улсын экспертизээр батлагдсан

Барилгын ажил

Нийт 6 барилгын ажлыг үргэлжлүүлэн ажиллаж байгаа бөгөөд ажлын явцыг дараах хүснэгтэд харуулав. Нийт барилгын ажлын явц 20.94% байна


№	Багцын дугаар	Ажлын нэр	Бодит явц	
			2021.06.25-ны байдлаар	2022.01.25-ны байдлаар
Бүрэлдэхүүн 1				
	ЕХОБ-ны санхүүжилт			
1	HSSC-A1	Шинэ суурьшлын бүсэд хийгдэх сайжруулсан нүхэн жорлон суурилуулах	60.00%	95.00%
2	USF	Морингийн шинэ суурьшлын бүсийг инженерийн хангамжийн шугам сүлжээнд холбох	12.98%	43.61%
Бүрэлдэхүүн 2				
	АХБ-ны зээл			
3	SHS	Нүүлгэн шилжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх 126 айлын түрээсийн орон сууц	15.66%	42.38%
4	ASKG-BKH	Цэцэрлэг	5.20%	10.97%
5	DDCD-BKH	Олон нийтийн хөгжлийн төв	7.18%	13.33%
6	DDPK-BKH	Цэцэрлэгт хүрээлэн	20.08%	59.58%

ХӨТӨЛБӨРИЙН III ҮЕ ШАТ

Хөтөлбөрийн III үе шатны байршлуудыг “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Техник эдийн засгийг үнэлгээ (ТЭЗҮ)-г зүүн бүсийн Шархад, баруун бүсийн гэр хороолол болох Толгойт дэд төвүүд дээр хийж гүйцэтгэн Төслийн Удирдах хорооны 2019.11.11-ний өдрийн хурлаар дээрх байршлуудыг хэлэлцүүлэн батлуулсан.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020.07.31-ны 125 тоот тогтоолоор дэд төвүүдийн байршил талбайн хэмжээг дараах байдлаар эцэслэн тогтоосон. Үүнд:

- Сонгинохайрхан дүүргийн 1,2,3,34,35 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Толгойт дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 736,9 га талбайд”
- Баянзүрх дүүргийн 8,9,10,17,19,24 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх “Шархад дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 507 га талбайд”



ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ЯВЦ

Хөтөлбөрийн 3 үе шатны хүрээнд хэрэгжүүлэх “Толгойт дэд төв”-ийн үерийн далангийн газар чөлөөлөлтийн нөлөөллийн суурин судалгааг боловсруулсан ба судалгааны дэлгэрэнгүй жагсаалтыг Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас гаргуулахаар 2021.01.18-ны өдөр албан тоотыг хүргүүлсэн.

Шархад дэд төвийн хүрээнд хэрэгжүүлэх Олон нийтийн хөгжлийн төв болон цэцэрлэгийн барилга баригдах байршлыг “НОСК” ХК-ийн чөлөөлөлт хийгдсэн “Цайз Эко хотхон” нэгж хорооллын Баянзүрх дүүргийн 19-р хорооны чөлөөлөгдсөн байршилд барихаар зөвшилцсөн ба газрын эрхийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулж өгөх тухай албан бичгийн 2021.01.14-ний өдөр хүргүүлсэн ба Газар барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулагдахаар хүлээгдэж байна.

Төслийн зураг төслүүдийн судалгааны ажлууд дуусан зураг төслүүдийг боловсруулж эхэлж байгаатай холбогдуулан дараах хүснэгтэд заасан нэгж талбарыг чөлөөлөхөөр төлөвлөөд байна.

Байршил	Барилгын ажлаар	Нөлөөлөлд өртөгчид
---------	-----------------	--------------------

		Нийт	Бүтэн	Хагас	Газрын эрхгүй
Толгойт	Автозам	98	26	39	33
	Дугуйн зам	93	16	46	31
	Автозам , инженерийн шугам сүлжээ	648	171	261	216
	Үерийн далан	203	88	47	68
	БИТ	1	1		
	УДДТ	48	27	5	16
Нийт		1091	329	398	364
Шархад	УДДТ	1	1		
	Автозам , инженерийн шугам сүлжээ	994	436	340	218
Нийт		995	437	340	218
Нийт		2086	766	738	582

Тайлант хугацаанд дараах хэсгүүдийн газруудыг чөлөөлөн нөхөн олговрыг олгоод байна


Байршил	Нөлөөлөлд өртөгчдийн тоо			Олгосон нөхөн олговрын хэмжээ
	Нийт	Нөхөн олговор авсан	Нөхөн олговор авахаар хүлээгдэж буй	
	2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/1043			
Толгойт	1	1		139,600,300
	2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/352			
Шархад	1	1		114,893,535
	Нийт дүн			254,493,835

Тайлант хугацаанд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна

- Толгойт дэд төвийн үерийн далангийн нөлөөлөлд өртсөн нийт 37 өрхөд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн явцын мэдээллийг хүргэх зорилгоор мэдээллийн хуудас хүлээлгэн өгч ажилласан.
- Толгойт дэд төвийн хүрээнд хийгдэх Бизнес инкубатор төв, Цэцэрлэгт хүрээлэнгийн ажлын ГЧНШ-ийн баримт бичиг болох Нийцтэй байдлын тайланг батлуулахаар АХБ-нд илгээсэн.
- Үе шат 3 хүрээнд хийгдэх хөрөнгийн үнэлгээний талаар үнэлгээний компанийн захирал н.Энхболдтой уулзалт хийсэн.
- Шархад дэд төвийг Амгалан дулааны станцаас дулаанаар хангах боломжгүй болсон учраас зураг төсөлд өөрчлөлт оруулахаар зураг төслийн багтай хэлэлцэж байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Уг санхүүжилтийн хүрээнд нийт 20 барилгын ажил, 1 бараа, 3 зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг хийхээр төлөвлөөд байгаа бөгөөд ХАА-ны ажлын явцыг дараах графикаас харна уу.



- **T3-CS01: Дэд төвийг дахин хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ**
Үнэлгээний хорооны тушаалыг 2021 оны 7-р сарын 28-нд байгуулсан. Ажлын даалгаварт өөрчлөлт оруулан эцэслэн батлуулахаар 2021.08.11-нд илгээсэн. Ажлын даалгаврыг 2021.09.13-нд банк баталсан бөгөөд тендерийн зарыг 9.14-нд зарласан. Санал хүлээн авах эцсийн хугацаа 2021.10.04-нд товлотсон. Санал хүлээн авах эцсийн хугацаанд нийт 9 материал хүлээн авсан. Үнэлгээний тайланг боловруулж Submission 1-ийг банканд 2021.11.9-нд илгээсэн. Банкнаас 2021.11.15, 28, 12.4, 8, 12, 14, 22, 1.7, 19 болон 20-нд тус тус зөвлөмж ирүүлсэн. Хариуг бэлтгэн 2021.11.19, 29, 12.5, 9, 13, 17, 1.3, 10, 19, 24-нд тус тус хүргүүлсэн. АХБ-наас 1.26-нд Submission 1-ийг баталсан.
- **SHTSC: Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил**
Тендерийг 2021 оны 11-р сарын 17-нд зарласан. Материал хүлээн авах эцсийн хугацаа 2021 оны 12-р сарын 17-нд товлотсон. Товлосон хугацаанд нэг санал хүлээн авсан. Үнэлгээний хороо үнэлгээг эхлүүлж тайлан боловсруулж байна
- **SHTSC-A: Сонгинохайрхан дүүрэг 1, 2, 20-р хороо, Цэргийн хотхон орон сууцны хороолол орчмын Б хэсэгчилсэн талбай дахь гадна дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил**
Үнэлгээний хороог 2021 оны 11-р сарын 30-нд байгуулсан. Тендерийн баримт бичгийг боловсруулж байна.
- **SHTSC-B: ГХДТ-2019-1 багцын орон сууцны “Оргил” төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил**
Үнэлгээний хороо байгуулж тендерийн баримт бичгийг боловсруулж байна.

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦ

Хөтөлбөрийн III үе шатыг яаралтай эхлүүлэн цаг хугацаанд нь дуусган хүлээлгэн өгөх зорилгоор нийгмийн барилга байгууламжийг өмнөх үе шатуудад хэрэгжүүлсэн нэг маягийн зургаар хийх бөгөөд дэд бүтцийн нарийвчилсан зураг төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан зураг төсөл боловсруулалтын ажлыг эхлүүлээд байна

Тайлант хугацаанд Толгойт дэд төвийн Үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанитай гэрээ байгуулан ажилласан бөгөөд ГЧНШ-ын асуудлаас шалтгаалан барилгын ажил эхлүүлэхийг хойшлуулаад байна.

10. Цаашид хийхээр төлөвлөсөн ажлууд:

АХБ-ны ажлын хэсгийн санамж бичгийг холбогдох талуудаар албажуулах

Хөтөлбөрийн I үе шатны ажлуудыг бүрэн дуусган улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах

Хөтөлбөрийн II үе шатны зураг төслийн ажлуудыг эрчимжүүлэн зураг төслийг 2022 оны I р улиралд багтаан дуусгахаар ажиллах

Хөтөлбөрийн III үе шатны зураг төсөл боловсруулалтын ажлуудыг эрчимжүүлэх

11. Тулгамдаж буй асуудлууд:

Төслийн хэрэгжилтийг удаашруулж буй дараах асуудлууд байна. Үүнд:

№	Тулгамдаж буй асуудал	Боломжит шийдэл
1	Нийслэлийн төсөв хүрэлцээгүйн улмаас 2020 оны 09 дүгээр сараас хойш өнөөдрийг хүртэл (460 гаруй хоног) нийт 14 гэрээт ажлын 27 ААН байгууллагад 20,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.	Захирамжийн төслийг 2021 оны 12 дугаар сараас эхлүүлж, төсвийн эрх нээгдэнгүүт аль болох богино хугацаандгүйцэтгэгчдэд санхүүжилтийг олгох.
2	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 10 сарын 08-ны өдрийн Эрх олгох тухай А/1182 тоот захирамжийг хэрэгжүүлж ажиллах хүрээнд тухай бүр байгуулагдах үнэлгээний хороонд НЗДТГ-ын төлөөллийг оролцуулахаар албан хүсэлтийг хүргүүлж, шаардлагатай сургалтыг зохион байгуулсан хэдий ч НЗДТГ-аас ирсэн жагсаалтад багтсан ажилчдын АЗ-ын хүчинтэй хугацаа ихэвчлэн дууссан байх ба үнэлгээний хороонд орж ажиллахаас татгалзсан хариу өгдөг нь төслийн хэрэгжилтийг удаашруулах нөхцөл байдлыг бий болгож байна.	АЗ сертификаттай төлөөллийн нэрсийн жагсаалтыг тухай бүрт нь ТХН-д мэдэгдэж, төлөөллийг оролцуулж байх тал дээр дэмжлэг үзүүлэх.
3	2021 онд барилга угсралт эхэлсэн гэрээт ажлуудын хувьд тодорхой хэд хэдэн хүчин зүйлүүдээс шалтгаалан бараа материал, түүхий эдийн үнийн өсөлт нь гэрээний нийт дүнд болон гэрээний хэрэгжилтийн хугацаанд нөлөөлж байна.	Үнийн өсөлтийн талаар ТХН-ээс гаргасан уулзалтуудыг зохион байгуулахад оролцон хамтарсан шийдвэрийг гаргах.

4	Барилга угсралтын ажилд ашиглагдах БНХАУ-аас оруулж ирэх бараа, материал хил, гааль дээр удаж байгаа нь төслийн нийт хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.	Бараа, материалыг яаралтай горимоор оруулж ирэхэд дэмжлэг үзүүлэх.
5	Төсөл 1-ийн хүрээнд баригдсан барилга, инженерийн шугам сүлжээ, авто замын байгууламж зэрэг эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтыг хариуцан ажиллах байгууллагуудыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан хэдий ч өнөөдрийг хүртэл хөрөнгийг албан захирамжаар ашиглагч, өмчлөгчид хүлээлгэж өгч чадахгүй байна.	НЗДТГ-ын Төрийн сангийн хэлтэсээс эзэмшигч, өмчлөгчид тухайн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр шилжүүлэх эсэхийг яаралтай шийдэх
6	Төслийн хүрээнд бий болсон тохижилт, үерийн далан зэрэг барилга байгууламжийг эзэмшигч, ашиглагч байгууллагыг тодорхойлоход хугацаа алдснаас шалтгаалаад барьж байгуулсан ажлуудын чанар муудах, захиалагч гүйцэтгэгчдийн хооронд маргаан үүсэх, цахилгаан, дулаан, ус, газрын хянан баталгааны дүгнэлт гаргуулах зэрэг төлбөрийг хэн төлөх нь тодорхойгүй нөхцөл байдал үүсэж байна.	Барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдаж баталгаажих явцад эзэмшигч, ашиглагч байгууллагыг тодорхойлох.
7	Нийт 103.5 тэрбум төгрөг газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажилд шаардлагатай байгаа ба уг саналыг 2022 оны төсөвт хүргүүлсэн хэдий ч 42 тэрбум төгрөгийн хангалтгүй төсөв батлагдсан нь төслийг 2023 онд төлөвлөсөн хугацаанд нь дуусгахгүй байх нөхцөл байдлыг бий болгож байна.	
8	“Зургаан буудал” ТББ, иргэд, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хамтран байгуулсан “Гомдлыг барагдуулах ерөнхий санамж бичиг”-ийн дагуу нөлөөлөлд өртсөн газрын эрхгүй иргэдийг Түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах шаардлагатай байна. Энэ талаар НОСК-д хүсэлт хүргүүлж, уулзалт зохион байгуулсан	

	хэдий ч шийдэлд хүрээгүй. Түүнчлэн 2018 онд анх иргэдтэй зөвшилцөх үеийн орон сууцны м2 үнэ өнөөдрийн байдлаар 30% орчмоор өсөөд байна.	
9	Инженерийн барилга байгууламжийн байршилд хамгаалалтын зурвасаар газар чөлөөлөлт хийх шаардлага тавьдаг. Гэвч хамгаалалтын зурвасаар газар чөлөөлөлт хийх нь төсөвт хүндрэлийг учруулдаг.	Нийслэлийн хот байгуулалт төлөвлөлтийн газраас инженерийн барилга байгууламжийн хамгаалалтын зурвасыг заавал оруулж газрыг чөлөөлөх эсэх тал дээр Улсын комиссод тайлбар, тодруулга хүргүүлэх.
10	Газар чөлөөлөлт хийгдсэн байршилд ашиглагч байгууллагад газар эзэмшүүлэх тухай захирамж гаргуулах үйл ажиллагаа нь олон шат дамжлагатайн улмаас төслийн ажлуудыг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.	Архитектур төлөвлөлтийн даалгавар авах талаар шийдлийг Нийслэлийн хот байгуулалт төлөвлөлтийн газраас тодруулах.
11	Газар чөлөөлөлтөд өртсөн иргэдэд газар болон үл хөдлөх эд хөрөнгийн нөхөн олговор олгох тухай НЗД-ын захирамж гаргах процесс нь олон шат дамжлагатайн улмаас төслийн хэрэгжилтийг удаашруулж байна.	Нийслэлийн 2022 оны төсвөөс санхүүжих нөхөн олговрын захирамжийг дэд төвөөр нь ангилан багцалж шуурхай гаргахад дэмжлэг үзүүлэх.
12	Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтад 37.02 Гкал/ц дулааны ачаалал шаардлагатай тооцоо боловсруулагдсан хэдий ч Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-иас 11.4 Гкал/ц ачааллыг хангах боломжтой тооцоолол ирүүлсэн.	Үлдэгдэл 25.62 Гкал/ц дулааны ачааллыг хангах дулааны эх үүсвэрийг Эрчим Хүчний Яамнаас шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
13	Шархад дэд төвийн 507га газрын төлөвлөлтөөр дулаан хангамжийн 112.0 Гкал/ц дулааны ачааллын техникийн нөхцөл шаардлагатай байна	Шаардлагатай хөрөнгийг шийвэрлэж, техникийн нөхцөлийг Эрчим Хүчний Яамнаас гаргуулахад дэмжлэг үзүүлэх.
14	Өвлийн оргил ачааллын үед төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолж ажиллах, Дэнжийн мянга дэд төвийн 80 Гкал/ц хүчин чадалтай дулааны эх үүсвэр, өндөр хүчин чадлын дулаан дамжуулах төвийн барилга байгууламжийг барихад шаардлагатай 3.8 га газрыг чөлөөлөхөд 10.86 тэрбум төгрөг, дээрх барилга байгууламжийг	Шаардлагатай байгаа 38.36 тэрбум төгрөгийн хөрөнгийг Нийслэлийн 2022 оны төсөвт суулгах

	барихад 27.5 тэрбум, нийт 38.36 тэрбум төгрөг шаардлагатай байна.	
15	2019, 2020 оны өвөл, Сэлбэ дэд төвийн Чингэлтэй уулын үерийн даланд хөрсний усны улмаас халиа дошин үүссэн. Сэлбэ дэд төвд 0.6км хөрсний ус доошлуулах шугам шинээр төлөвлөх шаардлагатай. Зуслан руу чиглэсэн хөдөлгөөний ачааллыг бууруулах, Сэлбэ төвд баригдсан авто замыг бүрэн дүүрэн ашиглаж автозамын түгжрэлийг бууруулахад Хайлааст, Дарь эхийн авто замтай холбосон 0.9км орчим авто замыг шинээр төлөвлөх шаардлагатай байна. Энэ нь дэд бүтцийн хоорондын уялдаа холбоог хангах чухал ач холбогдолтой юм. Сэлбэ дэд төвийн хил хязгаараас гадна Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, сэлбэ голын зүүн эрэг дагуух 64 өрх усанд автах эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн. Урьдчилсан судалгаагаар 830м орчим үерийн хамгаалалтын далан хийх шаардлагатай.	Дээрх ажлын зураг төслийг боловсруулах болон шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх
16	2021 оны эцсээр Сэлбэ дэд төвийн дулааны станц, ариутгах татуургын шугам ашиглалтад орохтой холбоотойгоор Дамбадаржаа дахин төлөвлөлтийн хүрээнд хийгдсэн ариутгах татуургын шугамд хөрсний ус нэвчсэн	Яаралтай засварлуулах ажлыг зохион байгуулах.

12. Шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

2022 оны НЗДТГ-ын төсөвт 2020, 2021 оны хүлээгдэж буй төлбөрүүд болон 2022 онд барилгын ажилд шаардагдах санхүүжилтийг бүрэн тусгаагүйгээс төслийн ажлууд 2023 онд хэрэгжиж амжихгүйд хүрэх эрсдэл үүсэж байгаа тул төсвийн тодотголоор нэмэлт төсөв батлуулж өгөх шаардлагатай

13. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл:

- а. Төслийн захирлын нэр: Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Засаг даргын Хүний хөгжил, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч
- б. Төслийн зохицуулагчийн нэр: Д.Авирмэд

в. **Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу 1, Амарын гудамж 2, Соёлын төв өргөө, Г корпус #415

г. **Холбоо барих утас:** + (976)-7000-3099

д. **Цахим шуудангийн хаяг:** info@ub-subcenter.mn